

Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын
2025 оны сарын өдрийн тоот
тогтоолын 1 дүгээр хавсралт

**БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭН
АЖИЛЛАХ “БУЛГАН СУМЫН СЭРГЭЛТ”
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Булган сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлого, дунд хугацааны “Шинэ сэргэлтийн бодлого” зорилтот хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Аймгийн засаг даргын Булганы сэргэлт 2024-2028 бусад бодлогын баримт бичгийг үндэслэсэн.

Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааг Монгол улсын 2021-2025 онд хэрэгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны сонгуульд оролцсон Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналыг тусган боловсрууллаа.

Хөтөлбөрийн зорилгыг “Булган сумын сэргэлт нь үйлдвэржилт дэд бүтэц, боловсрол, соёл, эрүүл мэндийн хүртээмж, ажлын байр нэмэгдүүлсэн, бизнесийн таатай орчин бүрдүүлж иргэд орон нутагтаа амар тайван, аз жаргалтай амьдрах”-д оршино гэж тодорхойлсон.

Хөтөлбөр нь 4 үндсэн зорилгын хүрээнд 22 зорилтын 96 үйл ажиллагааг хэрэгжүүлж, тухайн үйл ажиллагааны хэрэгжилтийн ажил арга хэмжээ тус бүрийг жил бүрийн 12 дугаар сард сумын Засаг дарга, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан, төлөөлөгч бүрээс санал авч мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж иргэдэд тайланг тавина.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай, ээлтэй орчинд боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн, нийгмийн идэвхитэй Булган сумын эрүүл иргэнийг хөгжүүлнэ.

Эрүүл мэнд:

1.1.Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж боловсон хүчнийг байнгын тогтвортой ажиллах боломжоор ханган иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.1.Эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг айл өрх бүрээр хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй асаргаанд байдаг иргэдийг тус тус хамруулна.

1.1.2.Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга байгууламжийг шинэчлэх, тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж багийн өрхийн эмч, сувилагч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулна.

1.1.3.Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судас, хоол боловсруулах болон хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

1.1.4 Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарыг мэргэшүүлэх гадаад, дотоодод сургах, туршлага судлуулах замаар эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.1.5.Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, сумандаа тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтнуудад олгох дэмжлэг, урамшууллыг нэмэгдүүлнэ.

Боловсрол:

1.2.Багш, удирдах ажилтны мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэн суралцагсдын сурлагын ахиц амжилтыг дээшлүүлэх замаар бүх шатны боловсролын хүртээмж, чанар, үр дүнг нэмэгдүүлнэ.

1.2.1.Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэн хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ.

1.2.2. Сургууль, цэцэрлэгийн орчныг ногоон төгөл бүхий эко орчин бий болгоно.

1.2.3.Багш нарын сурч хөгжих, туршлага судлах нөхцөл боломжийг сайжруулж, сумандаа тогтвор суурьшилтай ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн багш нарт дэмжлэг үзүүлнэ.

1.2.4. Ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг олгож, мэргэжлийн эрх олгохыг бодлогоор дэмжинэ.

1.2.5.Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог нэмэгдүүлнэ.

1.2.6.Насан туршийн боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтын суурь боловсрол, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг зохион байгуулна.

1.2.7. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаанд жил бүр дэмжлэг үзүүлж, цэцэрлэгийн насны хүүхдийн дунд “Зөв хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.

Биеийн тамир, спорт:

1.3. Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, өвлийн спортыг хөгжүүлж, олон төрөлт спортын амжилтыг нэмэгдүүлнэ.

1.3.1.Нийтийн биеийн тамираар хичээллэх орчныг бүрдүүлнэ.

1.3.2.Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжихэд чиглэсэн дугуйн аялал, явган аялал, спорт бүжгийн төрлийг хөгжүүлнэ.

1.3.3.Үндэсний спорт, багийн спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

1.3.4.Өвлийн цана, тэшүүр, мөсөн шагайн спортыг хөгжүүлж спортын амжилтыг нэмэгдүүлнэ.

1.3.5. Албан байгууллага болон аж ахуй нэгж байгууллагуудыг чийрэгжүүлэлтийн танхим, өрөө, биеийн тамирын заал, фитнес клуб байгуулах уриалгыг дэвшүүлж, дэмжлэг үзүүлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татна.

Соёл, урлаг, аялал жуулчлал:

1.4.Соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах, өвлүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх, соёлын ордны боловсон хүчин, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.4.1.Соёлын ордны мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлж, ажилтнуудыг гадаад дотоодод мэргэшүүлэх, давтан сургалтад хамруулна.

1.4.2.Шилдэг бүтээл болон улсын, олон улсын чанартай уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан сумын хүүхэд, залуучууд, ардын авьяастан, соёлын ордны уран бүтээлчдийг шагнаж урамшуулах бодлого баримтална.

1.4.3.Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өвлөн уламжлуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

1.4.4.Бүх нийтийн соёлын боловсролыг хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.4.5.Хүүхэд залуучуудын онцлог хэрэгцээнд нийцсэн соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, соёл урлагийн авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.4.6.Булган аймгийн түүхэн 90 жилийн ойд зориулан Булган сумын иргэд, хөдөлмөрчдөөс гавьяат үйлстнийг алдаршуулан, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэхэд улс, аймаг, сумын төсөвт жил бүр тусгаж, төлөвлөгөө боловсруулан түүхэн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.

1.4.7.“Хөгжмийн боловсролтой хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.4.8. Булган сумын Баяр наадмыг жил бүр зохион байгуулна.

1.4.9. Соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийг дэмжих сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

1.5. Булган сумын онцлогт түшиглэсэн, төрөлжсөн байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

1.5.1.Булган сумын онцлог, түүх соёлын өвийг сурталчлан таниулж, тогтвортой аялал жуулчлалыг дэмжиж, эвинт арга хэмжээг нэмэгдүүлнэ.

1.5.2.Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг чадавхжуулж, үйлчилгээ, орчныг стандартын шаардлагад нийцүүлнэ.

1.5.3.Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнийг худалдаалах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.5.4. Булган сумын хүүхэд, залуучууд иргэдэд Түүх дурсгалын, соёлын өвийг танин мэдүүлэх, нутаг дэвсгэрийн аяллын маршрутыг зохион байгуулна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд:

1.6.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын тэгш оролцоог хангах замаар гэр бүлд чиглэсэн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.6.1.Өсвөр үе, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон, сонирхолтой өнгөрүүлэх, идэвх, оролцоог дэмжсэн арга хэмжээг жил бүр зохион байгуулна.

1.6.2.Төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотойгоор хүүхдийн хөгжил, идэвх оролцоог дэмжсэн секц дугуйлан, сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

1.6.3.“Сумын хамтарсан баг”-ийн ажиллах нөхцөл боломжийг сайжруулан, гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах замаар гэр бүлийн хүчирхийллийг бууруулна.

1.6.4.Залуу гэр бүл ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар шилжилт хөдөлгөөнийг бууруулж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжинэ.

1.6.5.Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулна.

1.6.6.Төрийн болон төрийн бус нийгмийн бүлгүүдийн олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллана.

Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн халамж, хамгаалал:

1.7.Сумын хүн амын хөдөлмөр эрхлэлт, өрхийн хөгжлийг дэмжин, ажилгүйдлийн түвшнийг бууруулж, дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.

1.7.1.Халамжаас хөдөлмөрт шилжиж, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг түр болон байнгын ажлын байраар хангана.

1.7.2. Өрхийн бичил бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжих ажлыг зохион байгуулна.

1.8. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.

1.8.1.Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн хөгжил, оролцоог хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.8.2.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.8.3. Жилд хоёроос доошгүй хөдөлмөр эрхлэлт ажлын байранд зуучлах өдөрлөгийн зохион байгуулж ажиллана.

ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан дэд бүтцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тогтвортой өсөлтийг бий болгоход чиглэсэн бодлогыг баримтална

Эдийн засаг:

2.1.Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлнэ.

2.1.1.Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой тодорхойлж, төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.1.2.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

2.1.3. Гадаад, дотоод, олон улсын төсөл хөтөлбөрийг сум орон нутагтаа татан авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн, үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

2.2.1.Жижиг, дунд үйлдвэр, орон нутгийн худалдаа эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

2.2.2.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

2.2.3.Худалдаа, үйлчилгээний салбарын чанар хүртээмжийг нэмэгдүүлж, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж үйлчилгээний соёл, стандартыг хангуулна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ:

2.3.Орон нутгийн нөөц давуу талд түшиглэсэн бизнесийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.3.1.Булган суманд хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.

2.3.2.Үйлдвэрлэл үйлчилгээг эрэлт нийлүүлэлтэд нийцүүлэн, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.3.3.Үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт хангалт, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

2.3.4. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулна.

2.3.5.Булган сумын нийтийн ахуй үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр хороололд нийтийн халуун ус, үсчин гоо сайхан, гутал засвар, хэвлэл мэдээлэл, түргэн үйлчилгээний цэгийг бий болгох ажлыг бодлогоор дэмжиж төр, иргэн, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

2.3.6. Булган сумын түлш, модны захын үйл ажиллагааг сэргээж, мод модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дээшлүүлэх боломж нөхцөлийг бий болгоно.

Хүнс, мал аж ахуй:

2.4. Малыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, мал аж ахуйн салбарын тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.4.1.Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

2.4.2.Мал эмнэлгийн салбарын чанар хүртээмж, үр дүнг сайжруулна.

2.4.3.Эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэн бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ.

2.4.4.Малын үржлийн ажлыг уламжлал, шинэчлэлтэй хослуулан хөгжүүлэх замаар нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлнэ.

2.4.5.МАН-н түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

2.5.Төмс, хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлнэ.

2.5.1.Төмс, хүнсний ногооны талбайг хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулна.

2.5.2.Хүлэмжийн тариалалт хадгалалт зоорь, нөхөрлөл, хоршоодыг дэмжих замаар хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.

Байгаль орчин:

2.6.Байгалийн нөөц баялгийг хамгаалж, нөхөн сэргээх, зохистой ашиглаж, байгалийн унаган төрхийг хадгална.

2.6.1.Усны нөөцийг хамгаална.

2.6.2.Ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлнэ.

2.6.3.Орчны бохирдлыг бууруулна.

2.6.4. Хүн амын баталгаат усан хангамжийг сайжруулна.

ГУРАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Газар зохион байгуулалт, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олголтын хүртээмжийг нэмэгдүүлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн өргөтгөл шинэчлэл, сумын онцлогт тохирсон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэн сумын хүн амыг нутагтаа тогтвортой амьдрах орчныг бүрдүүлнэ.

Хот төлөвлөлт, газар зохион байгуулалт, дэд бүтэц:

3.1.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан эрх зүйн харилцаа үүсгэх төлөвлөлтийн хэрэгжилтийг нэмэгдүүлнэ.

3.1.1.Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олголтыг газрын хэрэгцээт байдлын үнэлгээнд нийцүүлэн олгоно.

3.1.2.Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт, газрын кадастрын мэдээллийн цахим системээр газар олголтыг ил тод болгоно.

3.1.3.Шинэ суурьшлын бүсүүдэд хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

Зам тээвэр:

3.2.Булган сумын авто зам, замын байгууламжийн арчилгаа, үйлчилгээг чанаржуулж авто замын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

3.2.1.Булган сумын авто зам, замын байгууламжийг өргөтгөж, шинэчилнэ.

3.2.2.Сумын хэмжээнд авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.3.Булган сумын хатуу хучилттай авто зам, замын байгууламжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

3.2.4.Булган сумын явган хүний замыг нэмэгдүүлнэ.

3.2.5.Хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн арчилгаа, үйлчилгээг сайжруулна

3.2.6.Булган сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээнд сэргэлт хийж парк шинэчлэлтийг үе шаттай зохион байгуулан маршрут нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

3.3.Сумын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.3.1.Сумын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийгмийн болон инженерийн дэд бүтэц, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.3.2.Булган сумын төвийн болон гэр хорооллын гудамж, талбайн гэрэлтүүлгийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

3.3.3. Сууц өмчлөгчдийн холбоог шинэчлэн зохион байгуулж, оршин суугчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.

3.3.4. Булган сумын ногоон байгууламж болон зам талбай, хөшөө дурсгалын арчилалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хангамжийг нэмэгдүүлнэ.

3.3.5. Гэр хорооллын айл өрхүүдэд эко орчин буюу Ногоон төгөл хашаа хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3.6. Орон сууц, нийтийн эзэмшлийн зам талбай, гэр хорооллын гудамж, айл өрхийн хог хаягдлын ангилал ялгалтын савыг жил бүрэн нэмэгдүүлж, хуванцар сав баглааг дахин боловсруулах цех, үйлдвэрийг сэргээн сайжруулах ажлыг зохион байгуулна.

3.3.7. Хот тохижилт үйлчилгээний ангийн техникийн парк шинэчлэлтийг үе шаттайгаар сэргээн сайжруулж, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт хариуцсан нэгжийг бий болгоно.

3.3.8. Багийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, барилга байгууламжийг сэргээн шинэчлэх, өргөтгөх, шинээр төлөвлөх.

ДӨРӨВ. ЦАХИМ ЗАСАГЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Хууль, эрх зүйн, батлан хамгаалах:

4.1. Амар тайван, аюулгүй орчныг бий болгоно.

4.1.1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.1.2. Булган сумын төв, гэр хорооллыг гудамж, зам талбайг үе шаттайгаар камержуулна.

4.1.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс Замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, явган зорчигчийн аюулгүйн гарцыг үе шаттай нэмэгдүүлнэ.

4.2. Гамшгийн эрсдэлийн даван туулах, батлан хамгаалах талаар:

4.2.1. Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулна.

4.2.2. Сум, байгууллагуудын гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулж сургалт, дадлага зохион байгуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг ажиллах нөхцөлөөр хангаж техник, хэрэгслийг нэмэгдүүлнэ.

4.2.3. Ус, цаг уурын ажиглалтын болон болзошгүй байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сумын хэмжээнд бүрдүүлнэ.

4.3. Булган сумын батлан хамгаалах чадавхийг дээшлүүлнэ.

4.3.1. Иргэдийн батлан хамгаалах бэлтгэлжилтийг нэмэгдүүлнэ.

4.3.2. Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлнэ.

ЦАХИМ ЗАСАГЛАЛ, МЭРГЭШСЭН, ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА:

4.4. Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, ил тод хүргэнэ.

4.4.1. Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.4.2. Төрийн үйл ажиллагааны бүтээмж, хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлнэ.

4.4.3. Төрийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

4.5.Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлж, төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

4.5.1.Төрийн албан хаагчдыг гадаад болон дотоодын сургалтад хамруулж, туршлага судлуулан, мэдлэг ур чадварыг дээшлүүлнэ.

4.5.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлж, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулна.

4.5.3.Төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийн хамрах хүрээ, хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлнэ.

4.5.4.Төрийн байгууллагуудын материаллаг бааз, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.